



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/279

Улаанбаатар хот


Г.Мөнхчулууныг сургалтад хамруулах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1, Хууль зүй дотоод хэргийн яам, Сангийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 15/41/25 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Албан хэрэг хөтлөлт, архивын ажилтанд мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгох журам"-ын 3.1.4, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтыг тус тус ТУШААХ нь:

1. Тус албаны Захиргаа, санхүүгийн хэлтсийн Архивын эрхлэгч Ганбүргэдийн Мөнхчулуун нь 5 жил архивын чиглэлээр ажиллаж, мэргэшлийн ахлах зэрэг авах болзол шалгуур хангасан тул Архивын Ерөнхий газарт зохион байгуулагдах "Архив, албан хэрэг хөтлөлтийн онол, арга зүй" сэдэвт анхан шатны сургалтад дотоод журмын 4 дүгээр зүйлийн 4.1.7-т заасны дагуу 2019 оны 04 дүгээр сарын 01-нээс 2019 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийг дуустал хугацаанд хамруулж, цалинтай чөлөө олгосугай.

2. Г.Мөнхчулуунд дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.33 дахь заалтын дагуу сургалтад хамрагдсан хугацааны цалинг олгохыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

3. Г.Мөнхчулууны чөлөөтэй байх хугацаанд ажил үүргийг нь орлон ажиллах хуваарийн дагуу холбогдох ажилтанд хүлээлгэн өгч, хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга /Э.Энхцэцэг/-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Г. ГАНТӨМӨР

